



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/196

Булган сум

**Газар эзэмших эрхийн гэрчилгээний
хугацаа сунгах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн хуралдааны IX/19 дүгээр тогтоолоор баталсан “Булган сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн С.Оюунчимэг (ГЮ70070563)-ийн Булган сум 5 дугаар баг Анхдагчдын өргөн чөлөө 1 дүгээр гудамж 137 тоотод байршилтай 6308003629 нэгж талбар бүхий худалдаа, үйлчилгээний зориулалтаар эзэмшиж буй 767 м2 газар, М.Батсайхан (ГЮ68100175)-ны Булган сум 5 дугаар баг Хатанбаатар С.Магсаржав 2 дугаар гудамж 215г тоотод байршилтай 6308003640 нэгж талбар бүхий худалдаа, үйлчилгээний зориулалтаар эзэмшиж буй 788 м2 газрын газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг тус тус 15 жилээр сунгасугай.

2. С.Оюунчимэг, М.Батсайхан нартай газар эзэмшүүлэх гэрээг шинэчлэн байгуулж, гэрчилгээжүүлэн газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3. Газрыг зориулалтын дагуу зүй зохистой эзэмшихийг иргэн (С.Оюунчимэг), (М.Батсайхан) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ